

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
“АВЛИГАТАЙ ТЭМЦЭХЭД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ” ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
4.1.1.1.Иргэн, иргэний нийгмийн оролцоог хангахад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр:					
1	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн баталгаажсан санхүүгийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын тайланг олон нийтэд ил тод болгох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, хэрэгжилтийг хангах:	Тайлангийн тоо-1	Аудитын тайланг ил тод болгосон байна.	Үндэсний аудитын газрын СНАГ-2025/07/НА-СТА-ТТЗ кодтой ЦУОШГ-ын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг шилэнд данс shilendans.gov.mn, байгууллагын цахим хаяг namem.gov.mn-т олон нийтэд хуулийн хугацаанд буюу 2025 оны 04 дүгээр сарын 25-нд ил тод мэдээлж ажилласан. Газрын даргын 2025 оны А/243 дүгээр тушаалаар төрийн байгууллагын нэгдсэн www.gov.mn, www.shilen.gov.mn, www.namem.gov.mn цахим хуудсанд мэдээлэл оруулах эрх бүхий ажилтан, хяналт тавих нэгж, асуудал бүрээр мэдээлэл оруулах ажилтан зэргийг нарийвчлан зааж баталсан. www.gov.mn, www.shilen.gov.mn, www.namem.gov.mn цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагааны талаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллүүдийг хугацаанд нь байршуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мөн баталсан. ЦУОШГ-ын төсөв санхүүтэй холбоотой дараах тайланг www.shilen.gov.mn, www.namem.gov.mn цахим хаягт ил тод мэдээлж ажиллав.Үүнд: - ЦУОШГ-ын албан хаагчдын цалин тогтоолт, бодолт, олголт, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын ногдуулалт 2024 он, 2025 оны 1-3 улирлын байдалд төлөвлөгөөт бус дотоод аудитын тайлан. - Цаг, уур орчны шинжилгээний газрын 2025 оны 1, 2, 3 улирлын байдлаар “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний танилцуулга. - Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024-2025 оны хагас жилийн төлөвлөгөөт бус дотоод аудитын тайлан.	100%

				4. Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны 1-11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээ. 5. Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан.	
4.1.1.2.Төрийн бодлогыг боловсруулах явцад иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах чиглэлээр:					
2	Хууль тогтоомжийн төсөлд иргэн, иргэний нийгмийн байгууллагын саналыг авах зорилгоор олон нийтийн хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулахад идэвхтэй оролцох:	Хэрэгжилтийн хувь-100%	Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн үзэл, баримтлал хуулийн төслийг салбарын хэмжээнд хэлэлцүүлсэн байна.	Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлыг 5 багц болгон хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагыг хангасан Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай шинэчилсэн найрууллагын хуулийн төсөл боловсруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын болон Хуулийн төслийг боловсруулах зөвлөх үйлчилгээг мэргэжлийн баг, байгууллагаар гүйцэтгүүлсэн. “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай” шинэчилсэн найрууллагын үзэл баримтлал, хуулийн төслийг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр ЦУОШГ-ын хурлын танхимд олон талын оролцоотой хэлэлцүүлсэн ба байгууллагын цахим хуудсанд мэдээлж ажиллав https://namem.gov.mn/d/news/472 .	100%
4.1.1.3.Төрийн бодлогыг хэрэгжүүлэх, үнэлэх, судалгаа, дүн шинжилгээ хийхэд иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:					
3	Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж буй байдалд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх;	Хэрэгжилтийн хувь-100%	www.gov.mn , www.shilen.gov.mn , www.namem.gov.mn цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод, нээлттэй байршуулсан байна.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл, Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу Газрын даргын 2025 оны А/243 дүгээр тушаалаар төрийн байгууллагын нэгдсэн www.gov.mn , www.shilen.gov.mn , www.namem.gov.mn цахим хуудсанд мэдээлэл оруулах эрх бүхий ажилтан, хяналт тавих нэгж, асуудал бүрээр мэдээлэл оруулах ажилтан зэргийг баталсан.	100%

				Цаг уур, орчны шинжилгээний газрын “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилт 2023 онд 93,7%-тай үнэлэгдэж байсан бол 2024 онд мэдээлэл огт оруулаагүй 0%-тай, 2025 оны 1 дүгээр улиралд 0%, 2 дугаар улиралд 73.6%, 3 дугаар улиралд 43.3%-тай дүгнэгдсэнтэй холбогдуулан газрын хурлаар тушаалын хэрэгжилт, бодит нөхцөл байдлыг нэг бүрчлэн тулган хэлэлцэж, 2025 оны 12 дугаар сард бүрэн оруулах үүрэг даалгаврыг ЦУОШГ-ын харьяа 25 байгууллагад 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 01/794 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Мөн Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас 2025 оны 12 дугаар сарын 19-ны өдөр ЦУОШГ-ын харьяа 25 байгууллагын удирдлага албан хаагчдад “Шилэн индексийн тайлан илгээх, хүлээн авах, тайланг хянах, үнэлэх, хэвлэн нийтлэх, мэдээлэл засварлах” сэдэвт сургалтыг цахимаар зохион байгуулсан. surgalt-shilen.gov.mn Friday, December 19 · 3:00 – 6:00pm Time zone: Asia/Ulaanbaatar Google Meet joining info Video call link: https://meet.google.com/mdm-vtqi-ofe Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг 2025 оны 4 дүгээр улирлын мэдээг 100% ил тод байршуулсан.	
4.1.2.Төрийн бодлогыг хэрэгжүүлэх, үнэлэх, судалгаа, дүн шинжилгээ хийхэд иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:					
4	Авлигын эсрэг олон нийтийн кампанит ажлыг хамтран зохион байгуулах	Хэрэгжилтийн хувь-100%	Авлигыг мэдээлэх 110 дугаарын утсыг байгууллагын вэб сайт болон тусгай самбарт түгээн, сурталчилсан байна.	Авлигыг мэдээлэх 110 дугаарын утсыг байгууллагын вэб сайт болон тусгай самбарт түгээж сурталчилсан байна (Зураг 1, 2). Мөн АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Г.Ариунзаяа 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр “Авлига, түүний шалтгаан нөхцөл, хор хөнөөл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” сэдвээр 40 минут мэдээлэл өгч, сургалтын дараах албан хаагчдын сонирхсон асуултад хариулт өгсөн. НҮБ-аас Олон Улсын Авлигын эсрэг өдөр болгон зарласан 12 дугаар сарын 09-ний өдөр түгээсэн Авлигын эсрэг Залуустай хамт Шударга маргаашийг бүтээе! уриатай видео, Цаг уурч залуус авлигын эсрэг үйл ажиллагаанд нэгдэж байна, Би авахгүй, өгөхгүй зэрэг контентуудыг Цаг уур, орчны	100%

				шинжилгээний газрын facebook, namem.gov.mn, цахим хаягаар түгээж, мэдээллэсэн https://namem.gov.mn/d/video-news/532 (Зураг 3).	
4.2.Төрийн үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх иргэний нийгмийн байгууллагад дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр					
5	Нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдлийн стандартын дагуу ил болгоход иргэн, иргэний нийгмийн байгууллагын хяналтыг сайжруулах боломжийг бүрдүүлэх	Хэрэгжилтийн хувь-100%	Ил тод байршуулсан тайлангийн тоо	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл, Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу Газрын даргын 2025 оны А/243 дүгээр тушаалаар төрийн байгууллагын нэгдсэн www.gov.mn , www.shilen.gov.mn , www.namem.gov.mn цахим хуудсанд мэдээлэл оруулах эрх бүхий ажилтан, хяналт тавих нэгж, асуудал бүрээр мэдээлэл оруулах ажилтныг баталж, олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан 50 гаруй мэдээллийг 2025 оны 4 дүгээр улирлын мэдээг 100% ил тод байршуулсан.	100%
4.3.Иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх дэд хөтөлбөр					
6	Ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн суралцагч, олон нийтийн дунд семинар, хэлэлцүүлэг, акц зохион байгуулах	Хэрэгжилтийн хувь-100%	Ус, цаг уур, орчны шинжилгээний салбарт хэрэгжиж буй мэдээ мэдээллийг тухай бүр олон нийтийн хэвлэл мэдээлэл болон байгууллагын цахим хуудсанд тогтмол байршуулан олон нийтэд сурталчилж зохион байгуулсан байна.	Цаг уурын байгууллагын үйл ажиллагаа сурталчлах нээлттэй өдөрлөгийг явуулах чиглэлийг хүргүүлсний дагуу 21 аймагт, их дээд сургууль, дунд сургуулиудад мэргэжил сурталчлах өдөрлөгийг зохион байгуулж 3414 сурагч, оюутан, иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан (Зураг 4, 5, 6). Д.Сүхбаатарын талбайд БНСУ-ын 7 хоног нээлттэй хаалганы өдрөөр БНСУ-ын Кесо байгууллагатай хамтран “Улаанбаатар хот болон 21 аймгийн төвд агаарын чанарын станц суурилуулах” төсөл, төслийн явц, агаарын чанарыг хэмждэг багаж тоног төхөөрөмж, агаарын бохирдлоос өөрийгөө хэрхэн сэргийлж, хамгаалах, агаарын чанарын индекс болон agaar.mn цахим сайтын талаарх мэдээллийг олон нийтэд сурталчилж, танилцуулга, мэдээллийг түгээж ажилласан байна. ЦУОШГ-аас хариуцдаг eis.mn , icc.mn зэрэг үндсэн 23 сангаас 20 дэд санд 2025 оны мэдээ бүрдүүлэлтийн ажлыг холбогдох	100%


				төрийн байгууллагууд, хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүдийн 114000 гаруй мэдээгээр баяжуулалт хийгдсэн. 2025 оны эхний 11 дүгээр сарын байдлаар нийт 26 удаагийн цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл ажиглагдсан. Давхардсан тоогоор анхааруулга мэдээ 833, сэрэмжлүүлэх мэдээ 107, урьдчилан сэргийлэх мэдээ 11 удаа гаргаж олон нийтэд зарлан мэдээлэв. Анхааруулга мэдээг хүчтэй салхиар 124, шороон шуургаар 66, их бороогоор 95, шар усны үерээр 14, их цасаар 154, цасан шуурга 114, ой хээрийн түймрээр 37, хүйтрэлтээр 31, их халуунаар 23 удаа, аянга цахилгаан, мөндөр 80 удаа, нөөлөг салхиар 75 удаа түгээсэн. Сэрэмжлүүлэг мэдээг хүчтэй салхиар 38, шороон шуургаар 7, их цасаар 13, цасан шуургаар 29, цочир хүйтрэлтээр 3, их бороогоор 17 удаа, Урьдчилан сэргийлэх мэдээг хүчтэй салхиар 3, шороон шуургаар 2, цасан шуургаар 2, их цасаар 3, цочир хүйтрэлтээр 1 удаа тус бүр бичиж олон нийтэд хүргэж ажилласан. Ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн урьдчилсан мэдээг байнгын хүргэдэг сувгуудаас гадна иргэд, хэрэглэгчдэд шуурхай хүргэхийн тулд 04 дүгээр сараас DDISH компанитай хамтын ажиллагаа эхлүүлж, 300 000 гаруй хэрэглэгчдэд нь хиймэл дагуулын холбоогоор шуурхай хүргэж эхэлсэн. E Mongolia app-аар дамжуулан 2 сая орчим хэрэглэгчдэд нь 09 дүгээр сарын 12-ноос цаг агаарын мэдээг шуурхай хүргэж эхлээд байна. Мөн И-Монгол УТҮГ хамтран цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн мэдээллийг аппликейшны мэдэгдэл хэсгээр шууд дамжуулан эхэлсэн. Цаг агаарын мэдээллийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор өдөр тутмын 16 сайтад албан бичгээр API ашиглах талаарх мэдээллийг илгээсэн. Орон нутгийн УЦУОШТ-үүд харьяа аймгийнхаа нутаг дэвсгэрт модемд суурилсан систем, Хэнтий Дундговь аймаг вебд суурилсан системээр иргэддээ мессэжээр хүргэж байна. Нэг удаагийн үзэгдлийн хувьд хамгийн их нь 214 мянган хүнд мэдээлэл түгээдэг. Нийт давхардсан тоогоор 2.5 сая хэрэглэгчдэд хүрч байна.	
4.4.Иргэдийн шүгэл үлээх, мэдээлэх соёлыг төлөвшүүлэх дэд хөтөлбөр					

7	Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах	Хэрэгжилтийн хувь-100%	Авлигыг мэдээлэх 110 дугаарыг харьяа бүх байгууллагын мэдээллийн самбарт түгээж сурталчилсан байна.	Авлигыг мэдээлэх 110 дугаарыг харьяа бүх байгууллагын мэдээллийн самбарт түгээж сурталчилсан бөгөөд салбарын хэмжээнд ажиллаж байгаа Нийтийн албан тушаалтнуудад 11 дүгээр сарын 20-ны өдөр АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” цахим сургалт, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэстэй хамтран “Мэдэгдэл, тайлбарыг ямар үед гаргах, хамаарал бүхий этгээддээ захиргааны шийдвэр гаргасан тохиолдолд хуулийн ямар арга хэмжээ авагдах вэ” сэдэвт цахим сургалтуудыг зохион байгуулж нийт 104 албан хаагч хамрагдсан. Удирдлагын зүгээс дарамт шахалт үзүүлэхгүй гэдгээ агентлагийн даргын зүгээс удаа дараа илэрхийлэхийн зэрэгцээ 7 хоног бүрийн Даваа гаригт удирдах ажилтны шуурхай, сар нийт хамт олны өргөтгөсөн хурлыг хийж, асуулт, хариулт, тулгамдсан асуудлын шийдлийг нээлттэй хэлэлцдэг болсон. БОУАӨСайдын 2025 оны А/458 дугаар тушаалаар тус газрын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдөж Хяналт, дотоод аудитын хэлтсийг байгуулсан 2025 оны 06 дугаар сараас хойш удирдлагын үүрэг чиглэл, албан хаагчдын өргөдөл гомдлын дагуу нийт 4 удаа төлөвлөгөөт бус дотоод аудит, 7 өргөдөл, гомдлыг хянан шалгаж дараах үр дүнг гаргасан. Үүнд: 1. “Уур амьсгал, хөдөө аж ахуйн цаг уурын хэмжих хэрэгсэл, сэлбэг материал” нийлүүлэх /ЦУОШГ/20250601020/ дугаартай тендерийн гүйцэтгэгчээр шалгарсан “Гэрэгэ дижитал технологи” ХХК-ний нийлүүлсэн 3 төрлийн нийт 18 хэмжих хэрэгслүүд шаардлага хангахгүй, буцаагдсан асуудалд хяналт шалгалт хийсэн танилцуулга, дүгнэлтийн дагуу газрын 2 албан хаагч, харьяа байгууллагын 2 албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулсан. 2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.3.-д заасны дагуу үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавихад “Төв, орон нутгийн интернэтийн үйлчилгээ” ЦУОШГ/20250103001 дугаар бүхий	100%
---	--	------------------------	---	--	------

				тендерийн үнэлгээний хорооны нийт гишүүдийн 100 хувийн саналаар шалгаруулсан “ЭС АЙ СИ ТИ” ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмжид дотоод хяналт хийж, хууль тогтоомжид нийцэхгүй байгааг илрүүлж зөвлөмжийг буцаасан. 3. Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.3-т “шөнийн цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно”, 109.8-д “Ажилтныг ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно” заалтыг хэрэгжүүлээгүй, ЦУОШГ-ын даргын тушаал шийдвэргүйгээр шөнийн ээлжийн 22 албан хаагчдад шөнийн цагийн нэмэгдлэл хөлсийг 0.3 хувиар тооцож байсан алдааг илрүүлж, 2025 оны дутуу олгосон 30,631,733 төгрөгийн нэмэгдэл цалин хөлсийг нөхөж олгох шийдвэр гарсан. 4. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын 2.2.1.12-д заасны дагуу Ус цаг уурын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээнд зориулж иргэд, аж ахуйн нэгж, албан хаагчдаас хандивын орлого, зарлагын дэлгэрэнгүй тайланг ЦУОШГ-ын шилэн данс https://shilendans.gov.mn/, байгууллагын төсөв санхүүгийн ил тод байдал https://namem.gov.mn/ байршуулах зөвлөмж өгсөн.	
--	--	--	--	---	--



Зураг 1, 2. Авлигыг мэдээлэх 110 дугаарын утсыг байгууллагын вэб сайт болон тусгай самбарт түгээж сурталчилсан байдал



Зураг 3. НҮБ-аас Олон Улсын Авлигын эсрэг өдөр болгон зарласан 12 дугаар сарын 09-ний өдрийн салбарын видео контентийг түгээсэн байдал.



Зураг 4, 5, 6. Цаг уурын байгууллагын үйл ажиллагаа сурталчлах нээлттэй өдөрлөг